



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/10/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: В.Эрдэнэцогт
Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogtb@audit.gov.mn
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг
Утас: 70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	7
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	8
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	13
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	14
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.2 Албан шаардлага	22
5.3 Зөвлөмж	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
УБДС	Улаанбаатар дулааны сүлжээ



ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ү.ТӨМӨРХУЯГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 071819
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 13,895.7 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант оны эцсийн байдлаар 9 харилцагчтай холбоотой 137.3 сая төгрөгийн өглөг, 31 харилцагчтай холбоотой 281.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа нэг компанид давуу эрх олгож 7 удаагийн 7,176.6 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан ба тендерт оролцогчийн ажиллах хүчин, хүний нөөцийн хүчин чадлын мэдээллүүд нь эдгээр ажлуудыг нэгэн зэрэг гүйцэтгэх нөөц боломжгүй байхад сонгон шалгаруулсан ба энэ нь 4,836.3 сая төгрөгийн 3 гэрээт ажлыг хугацаа хоцроож гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлсэн;
- Нийт 6 төсөл, арга хэмжээний 1,361.1 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа 40.8 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг гаргуулан аваагүй буюу гэрээ байгуулах эрх үүсээгүй байхад хууль зөрчиж гэрээ байгуулсан;

- Худалдан авах ажиллагааны тайланг дутуу, алдаатай бэлтгэж ирүүлсэн, тендерийн материалыг хуулийн шаардлагад нийцүүлэн тендерийн баримт бичигт заавал хавсаргах баримт бичгийг иж бүрнээр нь хавсаргаагүй;
- Бараа материалын дансанд 5 буюу түүнээс дээш жилийн хугацаанд ашиглагдаагүй 789 нэр төрлийн 3,171.8 сая төгрөгийн насжилт өндөртэй бараа материалын нөөц үүсгэсэн

зэрэг зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: ... 5.1.4 Үнэн зөв байх; ...", ТБОНӨХБАҮХАТ хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", 43 дугаар зүйлийн 43.4-т "Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана: ... 43.4.1. 150 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил худалдан авах гэрээ байгуулах; 43.4.2. 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах; 43.4.3. хоёр жилээс дээш хугацаагаар үргэлжлэх худалдан авах гэрээ байгуулах; ...", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:... 15.1.6 нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх; ..." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Хөгжлийн банктай байгуулсан Турбоагрегат №1-4-н төслийн шинэчлэлийн 70,638,904.91 еврогийн зээлийг төгрөгт шилжүүлэн, хугацааг 3 жилээр сунгасан нь тус компанийн богино хугацаат өр төлбөрийг бууруулж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварт зэрэг нөлөө үзүүлсэн байна. 2024 оноос хугацаа хэтэрсэн зээлд тооцох нэмэгдүүлсэн хүү, валютын ханшийн зөрүү үүсэхгүй нь компанийн санхүүгийн үзүүлэлтэд ач холбогдолтой болсон байна.

Цахилгаан станц нь 1 сая м.куб дэгдэмхий үнс ба шлакны холимгийг 3-4 жилийн хугацаанд ялгаруулдаг бөгөөд мөн ийм давтамжтай үнс хадгалах байгууламж шинээр бий болгох шаардлагатай тул энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор 1,650,000 м3 эзлэхүүн бүхий үнсэн сангийн карт №2 ажлыг гүйцэтгэсэн нь ДЦС-4-ын үндсэн тоноглолын тасралтгүй найдвартай ажиллах нөхцөлийг бүрдүүлжээ.

Аудитын гол асуудал

Тус компани нь 466,702.2 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийн үлдэгдэлтэй, урт хугацаат зээлийн эргэн төлөлт хийгдэхгүй байгаа нь Эрчим хүчний зохицуулах хорооноос цахилгаан, дулааны борлуулалтын үнэ тарифыг өртгөөс нь бага үнээр тогтоож ирсэнтэй холбоотой ба үүнээс шалтгаалж компанийн ашигт ажиллагаа болон тасралтгүй үйл ажиллагаанд эрсдэл үүсэхээр байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн үйл ажиллагааны тайланд 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 7 бүлэг 24 ажил төлөвлөснөөс биелэлт нь 99.9 хувь, чанарын зорилтын хүрээнд 7 ажил төлөвлөж 100.0 хувийн биелэлттэй, компанийн эрсдэлийн төлөвлөгөөнд

10 хэсэгт 160 ажил төлөвлөснөөс 93.5 хувийн биелэлттэй, 2023 онд нийт 2144 аюул мэдээлэгдсэний 1944 аюул буюу 90.8 хувийг арилгасан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	/төгрөгөөр/ 2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,888,802,930.45	14,066,309,287.89
1.1.2	Дансны авлага	17,094,405,120.97	21,556,224,937.79
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	1,785,466,804.08	
1.1.4	Бусад авлага	724,378,120.67	492,789,215.60
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	29,111,125,951.02	29,642,429,553.28
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6,629,612,254.27	6,358,272,362.49
	Эргэлтийн хөрөнгийн дүн	61,233,791,181.47	72,116,025,357.05
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	872,114,260,839.25	843,456,526,874.37
1.2.2	Биет бус хөрөнгө	76,937,241,608.25	77,047,166,798.14
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	514,389,332.12	1,092,304,461.02
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	949,565,891,779.62	921,595,998,133.53
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,010,799,682,961.09	993,712,023,490.58
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,692,407,049.88	1,885,660,522.51
2.1.1.2	Цалингийн өглөг	5,298,260,381.88	6,801,086,633.17
2.1.1.3	Татварын өр	1,010,306,423.55	5,581,471,921.31
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл	143,091,087,448.37	17,636,287,204.27
2.1.1.6	Хүүний өглөг	818,874,830.22	791,402,599.39
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,003,819,608.62	1,000,301,544.91
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	1,146,722,448.25	4,087,902,688.64
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	845,606,920.69	1,465,850,480.61
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	154,907,085,111.46	39,249,963,594.81
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	289,995,706,305.56	390,116,249,809.56
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	13,059,122,758.46	13,018,062,058.50
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	8,356,560,857.11	7,305,387,027.86
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5	Хойшлогдсон орлого	17,926,910,170.01	17,012,543,709.65
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	329,338,300,091.14	427,452,242,605.57
2.2	Өр төлбөрийн нийт дүн	484,245,385,202.60	466,702,206,200.38
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: төрийн	227,071,740,030.34	227,071,740,030.34

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	257,661,148,835.64	257,661,148,835.64
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	78,008,219,977.00	78,008,219,977.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(36,186,811,092.37)	(35,731,291,552.78)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	526,554,297,750.61	527,009,817,290.20
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,010,799,682,953.20	993,712,023,490.58

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	319,326,128,173.29	430,276,925,672.40
2	Борлуулалтын өртөг	324,811,782,578.46	408,996,784,264.99
3	Нийт ашиг(алдагдал)	(5,485,654,405.17)	21,280,141,407.41
4	Түрээсийн орлого	173,163,206.81	192,278,595.39
5	Хүүгийн орлого		148,770,121.60
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	11,936,390,625.73	5,639,898,047.28
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,661,113,881.52	2,705,543,280.61
10	Ерөнхий ба удирдлагын зардал	4,722,963,200.95	6,507,216,926.76
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	9,632,898,019.69	10,128,440,926.15
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(39,583,806,928.28)	(2,286,387,018.72)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(77,912,837.75)	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		43,584,803.87
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(50,054,795,440.81)	5,677,084,823.31
19	Орлогын татварын зардал	354,793,196.17	4,515,174,976.90
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(50,409,588,636.99)	1,161,909,846.40
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(50,409,588,636.99)	1,161,909,846.40

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	227,071,740,030.34	311,515,695,204.19	78,008,219,977.00	(35,567,839,084.79)	581,027,816,126.74
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				(4,063,558,237.44)	(4,063,558,237.44)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	227,071,740,030.34	311,515,695,204.19	78,008,219,977.00	(39,631,397,322.23)	576,964,257,889.30
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		(53,854,546,368.55)		53,854,546,368.55	
Тайлант үеийн үр дүн				(50,409,588,636.99)	(50,409,588,636.99)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	227,071,740,030.34	257,661,148,835.64	78,008,219,977.00	(36,186,439,590.67)	526,554,669,252.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				(706,761,808.52)	(706,761,808.52)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	227,071,740,030.34	257,661,148,835.64	78,008,219,977.00	(36,893,201,399.19)	525,847,907,443.79
Тайлант үеийн үр дүн				1,161,909,846.41	1,161,909,846.41
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	227,071,740,030.34	257,661,148,835.64	78,008,219,977.00	(35,731,291,552.78)	527,009,817,290.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2021 оны 12 сарын 31	2022 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	315,579,289,623.55	406,770,690,205.0
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	313,025,288,930.61	404,445,333,734.5
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	2,554,000,692.94	2,325,356,471.26
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	311,680,122,119.25	376,335,551,600.6
1.2.1	Ажиллагчдад төлсөн	41,062,094,795.80	50,475,918,060.46
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	14,191,558,216.98	16,606,078,005.64
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	142,172,303,781.02	184,700,000,000.0
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	52,181,388,814.12	55,802,060,763.25
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	16,770,121,772.37	12,662,759,909.25
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	17,228,338,649.18	15,017,202,147.09
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	98,524,766.67	65,469,430.14
1.2.9	Бусад мөнгөн зарлага	27,975,791,323.11	41,006,063,284.86
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,899,167,504.30	30,583,908,726.72
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		148,770,121.60
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		148,770,121.60
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,851,440,872.48	2,092,808,816.17
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,995,323,066.02	2,092,808,816.17
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,856,117,806.46	
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,851,440,872.48)	(1,944,038,694.57)

3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,874,876,083.46	
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,874,876,083.46	
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,079,530,958.90	20,054,746,454.98
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,513,610,958.90	20,054,746,454.98
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	3,565,920,000.00	
3.2.5	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,204,654,875.44)	(20,054,746,454.98)
4	Валютын ханшийн зөрүү		(258,847,098.13)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(3,156,928,243.62)	8,177,506,357.44
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,045,731,174.07	5,888,802,930.45
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,888,802,930.45	14,066,309,287.89

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны			
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар
1	Боловсруулсан	ЦЭХ	сая кВт.ц	4,637.6	4,648.1	4,871.4	223.3	104.8
		ДЭХ	мян.Гкал	4,551.4	4,721.1	4,636.9	(84.2)	98.2
	ДХЦЭХ	хувиар	хувь	11.3	11.4	11.1	(0.3)	97.2
		биетээр	сая кВт.ц	526.1	532.2	541.9	9.7	101.8
	Эрчим хүч түгээлт	ЦЭХ	сая кВт.ц	4,111.5	4,115.9	4,329.5	213.6	105.2
		ДЭХ	мян.Гкал	4,551.4	4,721.1	4,636.9	(84.2)	98.2
2	Нийт орлого		сая төг	331,435.7	413,780.0	436,301.5	22,521.4	105.4
	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая төг	319,326.1	409,608.9	430,276.9	20,668.0	105.0
		Үйл ажиллагааны бус орлого	сая төг	12,109.6	4,171.1	6,024.5	1,853.4	144.4
3	Нийт зардал		сая төг	381,490.5	422,018.9	430,624.4	8,605.4	102.0
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая төг	336,631.7	417,847.8	423,678.4	5,830.6	101.4
		Үйл ажиллагааны бус зардал	сая төг	44,858.8	4,171.1	6,945.9	2,774.8	166.5
	Үүнээс: Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал		сая төг	62,468.2	62,397.5	65,694.5	3,297.0	105.3
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая төг	(50,054.8)	(8,238.9)	5,677.1	13,916.0	168.9
5	Татварын дараах ашиг /алдагдал/		сая төг	(50,409.6)	(8,238.9)	1,161.9	9,400.8	114.1
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		төг	1.2	1.0	1.0	(0.0)	96.8
7	Нийт авлага		сая төг	19,604.3	15,850.0	22,049.0	6,199.0	139.1
	Үүнээс:	ЭХ-ний	сая төг	17,470.5	15,000.0	21,556.2	6,556.2	143.7
		Бусад	сая төг	2,133.8	850.0	492.8	(357.2)	58.0
8	Нийт өглөг		сая төг	484,245.0	465,630.6	466,702.2	1,071.6	100.2
	Үүнээс:	Урт хугацаат өр төлбөр	сая төг	329,338.3	272,601.6	427,452.2	154,850.7	156.8
		Богино хугацаат өр төлбөр	сая төг	154,906.7	193,029.0	39,250.0	(153,779.0)	20.3
9	Нийт ажиллагсад		тоо	1,487.0	1,487.0	1,487.0	0.0	100.0
10	Нийт цалингийн сан		сая төг	49,900.0	62,813.7	62,813.1	(0.6)	100.0
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	цахилгаан	гр/кВт.ц	270.9	274.8	271.9	(2.8)	99.0
		дулаан	кг/Гкал	171.7	172.5	171.7	(0.8)	99.5
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая төг	27,005.8	47,466.4	38,583.1	(8,883.3)	81.3
	Үүнээс:	Их засвар	сая төг	19,566.0	45,569.8	37,134.2	(8,435.6)	81.5
		ТЗБАХ	сая төг	1,287.9	56.0	0.0	(56.0)	0.0
		Хөрөнгө оруулалт	сая төг	6,151.9	1,840.6	1,448.9	(391.7)	78.7

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь эрхэм зорилгоо “Эх орны хөгжлийн баталгаа, эрчим хүчний хүчирхэг тулгуур нь байна” гэж тодорхойлжээ.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг “цахилгааны, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хангах, түгээх, худалдах” гэж тодорхойлжээ.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийг Засгийн Газрын 2001 оны 164 дүгээр тогтоолыг үндэслэн бие даасан төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн өөрчлөн зохион байгуулсан байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨХК статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс Эрчим хүчний яам 66 хувь, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 34 хувийг эзэмшиж байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Компанийн удирдлагыг ТУЗ-ийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8-д “Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох”, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох” гэсэн заалтуудтай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль;
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- МУ-ын Засгийн газрын 2023 оны 03 сарын 07-ны 84 дүгээр тогтоол Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам;
- ТӨБЗГ-ын 2023 оны 05 сарын 11-ний 174 дүгээр тогтоолоор Төрийн өмчит компанийн ТУЗ-ын гишүүний цагийн цалин хөлсний хэмжээг тооцох, оролцоод суурилсан холимог аргачлал”
- Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах журам;
- Ажилтны мэдээллийг авах, боловсруулах, ашиглах, хадгалах журам;
- Сургалтын тэтгэлэг олгох журам;
- Техникийн зургийн цахим сан үүсгэх, эд ангийн зураг батлуулах журам;
- Ажилтнаас мэдлэгийн шалгалт авах журам (А/179);
- Албан тушаалын үндсэн цалин тогтоох, нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох журам;
- ДЦС-4” ТӨХК-ийн ажилтнуудад орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх, дараалал тогтоох, хуваарилах журам (А/199);

- Тоног төхөөрөмж, барилга байгууламжийг бүрэн болон хэсэгчлэн зогсоож засвар үйлчилгээний ажил зохион байгуулах журам (А/232).

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Эрчим хүчний Яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2023 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийсэн байна. Эрчим хүчний салбарын хэмжээнд хугацаандаа мэдээлэл байршуулалт 91.4 хувьтайгаас Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн хувьд 86.1 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн гэж дүгнэсэн байна.

Дотоод хяналтын ажилтны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын ажилтны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын ажилтнаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компанийн мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2021 оны 12 дугаар сард ТУЗ-ийн тогтоолоор баталсан байна. Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17,087.7 сая төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,888,802.9	14,066,309.3	8,177,506.4
Авлага	19,604,250.0	22,049,014.2	2,444,764.2
Бараа материал	29,111,126.0	29,642,429.6	531,303.6
Урьдчилж төлсөн зардал	6,629,612.3	6,358,272.4	(271,339.9)
Үндсэн хөрөнгө	949,565,891.8	921,595,998.1	(27,969,893.6)
Нийт хөрөнгө	1,010,799,683.0	993,712,023.5	(17,087,659.5)
Өр төлбөр	484,245,013.7	466,702,206.2	(17,542,807.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	526,554,669.3	527,009,817.3	455,149.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,010,799,683.0	993,712,023.5	(17,087,659.5)

Касс дахь бэлэн мөнгө 15.2 сая төгрөг, банк дахь харилцах данс 14,051.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөнгөн хөрөнгө 8,177.5 сая төгрөгөөр өссөн нь борлуулалтын орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 22,049.0 сая төгрөг болж 2,444.8 сая төгрөгөөр өсөхөд борлуулалтын авлага нөлөөлсөн байна.

Авлагын үлдэгдэлд ДҮТ ХХК-иас авах 21,241.4 сая төгрөг, УБДС ТӨХК-иас авах 309.1 сая төгрөг, үйлдвэрлэлийн байгууллагаас авах 665.3 сая төгрөг, бусад авлага 33.9 сая төгрөг, найдваргүй авлагын нөөц 693.4 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдлийг насжилтаар нь авч үзвэл хэвийн 22,467.0 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 276.0 сая төгрөгийн авлага байна. Найдваргүй авлагыг нөөцийн буюу хасагдуулгын аргаар тооцдог байна. Тайлант онд 693.5 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулсан байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй 276.0 сая төгрөгийн бусдаас авах авлага байна. Энэ нь зарим харилцагч компаниудын авлага барагдах боломжгүй талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх тогтоолтой, холбоо тогтоох боломжгүй зэрэг асуудлаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 29,642.4 сая төгрөг болж 531.3 сая төгрөгөөр өссөн нь нүүрс, мазут болон сэлбэг хэрэгслийн худалдан авалтын өсөлтөөс ихээхэн шалтгаалжээ.

Бараа материал худалдаж авсан 249,235.3 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагааны зардалд зарцуулсан 247,520.3 сая төгрөг хасагдсан байна.

Тайлант онд 2,314 нэр төрлийн 12,397.8 сая төгрөгийн бараа материалд 1,587.7 сая төгрөгийн үнэ цэнийн бууралт тооцсон байна.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 6,358.3 сая төгрөг болж 271.3 сая төгрөгөөр буурсан нь бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа, бусад татварын урьдчилгаа тус тус буурсантай холбоотой байна. Мөн санхүүгийн тайлангийн аудитын залруулгаар үндсэн хөрөнгийн хувь тэнцүүлсэн падааны нэгээс дээш жил хасагдах дүнг эргэлтийн бус хөрөнгөд залруулан бүртгэсэн нь нөлөөлжээ.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэлд бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа 152.9 сая төгрөг, Багануур ХК-д төлсөн нүүрсний урьдчилгаа 1,179.9 сая төгрөг, Шивээ овоо ХК-д төлсөн нүүрсний урьдчилгаа 305.1 сая төгрөг, МЗХНН-т төлсөн тээврийн хөлсний

урьдчилгаа 2,979.0 сая төгрөг, урьдчилж төлсөн зардал 527.7 сая төгрөг, НӨАТ-ын хувь тэнцүүлсэн падааны 2024 онд хасагдах зардал 1,213.7 сая төгрөг төлбөрүүд тус тус бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,203.9 сая төгрөг, капиталжуулалт хийсэн 34,816.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл 110.0 сая төгрөгөөр өссөн нь программ хангамж нэмэгдсэн байна.

Бусад эргэлтийн бус хөрөнгийн үлдэгдэл 1,092.3 сая төгрөг болж 577.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь завсрын аудитын зөвлөмжийн дагуу үндсэн хөрөнгийн хувь тэнцүүлэн хасагдуулах НӨАТ-ын авлагыг тус дансанд залруулан бүртгэсэнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 39,249.9 сая төгрөг болж 115,656.8 сая төгрөгөөр буурсан нь Хөгжлийн банкны зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж төлөх хугацааг 3 жилээр хойшлуулж 2024 оны 02 дугаар сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор НББОУС-10-аар тайлагналын дараах үйл явдлаар хүлээж зөвшөөрч өмнөх тайлант үед хугацаа хэтэрсэн болон нэг жил дотор төлөгдөх 166,008.8 сая төгрөгийг урт хугацаат зээлд шилжүүлэн бүртгэсэн нь нөлөөлжээ.

Богино хугацаат зээлийн үлдэгдэлд Сангийн яамны дамжуулан зээл, хөгжлийн банкнаас тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх зорилгоор 2012-2021 онуудад авсан зээлийн графикайн дагуу 2024 онд төлөх урт хугацаат зээлээс шилжүүлэн бүртгэсэн 17,636.3 сая төгрөгийн зээл бүртгэлтэй байна.

Нөөц өр төлбөр дансанд ахмадын сангийн нөөц өр төлбөр 31.0 сая төгрөг, ажилчдын тэтгэврийн нөөц өр төлбөрийн актуар тооцооны богино хугацаанд хамаарагдах 4,057.0 сая нийт 4,087.9 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 427,452.2 сая төгрөг болж 98,113.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь богино хугацаат өр төлбөрөөс шилжин ирсэн 166,008.8 сая төгрөгийн өсөлт болон 2024 онд Сангийн яам болон УБДС ТӨХК-д төлөх 37,035.2 сая төгрөгийг богино хугацаат өр төлбөрт шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Урт хугацаат зээлийн үлдэгдэлд 2018-2021 онд Турбоагрегат №1-4-н шинэчлэлийн төслийн шинэчлэл хийх зорилгоор 7 жилийн хугацаатай Хөгжлийн банкнаас авсан 257,359.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл, УБДС ТӨХК-с Эрчим хүчний дулааны үр ашиг дээшлүүлэх дамжуулан зээлийн 2012 онд авсан 24 жилийн хугацаатай 3,103.5 сая төгрөг, 2012-2021 онуудад үүссэн Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, зуух, турбины хяналт удирдлагын системийг шинэчлэх төслийн арга хэмжээний дамжуулан зээлийн 24-35 жилийн хугацаатай Сангийн яамнаас авсан 129,653.7 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл нийт 390,116.2 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр бүртгэлтэй байна.

Тайлант хугацаанд хуримтлагдсан алдагдал 455.1 сая төгрөгөөр буурсанд жилийн эцэст 1,161.9 сая төгрөгийг ашигтай ажилласан нь нөлөөлсөн, мөн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт алдааны залруулгаар 706.8 сая төгрөгийг алдагдалд бүртгэсэн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3.20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь

байгууллагын техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2023 оны А/10 дугаар тушаалаар компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 398,994.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 408,994.2 сая төгрөгөөр, 10,000.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 36,475.0 сая төгрөгийг төлөвлөжээ.

Эрчим хүчний сайдын 2023 оны А/178, А/291 дүгээр тушаалаар нийт орлогыг 413,780.0 сая төгрөг, нийт зардлыг 422,018.9 сая төгрөг, алдагдлыг 8,238.9 сая төгрөг, их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын арга хэмжээг 47,466.4 сая төгрөг болгон тус тус тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 436,301.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, зардал 430,624.4 сая төгрөгт хүрч, 5,677.1 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 436,301.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 22,521.4 сая төгрөг буюу 5.4 хувиар давсан нь боловсруулсан цахилгаан эрчим хүчний хэмжээ 5.2 хувь, дулааны эрчим хүчний хэмжээ 0.2 хувиар өссөнөөс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 430,624.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 8,605.4 сая төгрөгөөр илүү байна. Энэ нь цахилгаан эрчим хүчний зардал 9,074.4 сая төгрөг, үйл ажиллагааны бус зардал 2,774.8 сая төгрөгөөр тус тус хэтэрч, дулааны эрчим хүчний зардал 3,243.8 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Үндсэн тоноглолын их засвар, туслах тоноглолын их засвар, барилгын их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний 230 ажилд 47,466.4 сая төгрөгийг төлөвлөж, 38,583.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ба 8,883.3 сая төгрөгийн хэмнэлт нь 2024 оны засварын ажлын бэлтгэл хангахад 10,991.4 сая төгрөгийг тодотгон төлөвлөсөн нь гүйцэтгэлээр гараагүй, өмнөх оноос дамжсан их засварын 4,551.6 сая төгрөгийн гүйцэтгэл нэмэгдэж хэтрэлттэй харагдаж байгаа боловч 2023 оны төлөвлөлт, гүйцэтгэлийг харьцуулж үзэхэд 2,443.5 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Тайлант онд 8,238.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 5,677.1 сая төгрөгийн ашигтай ажиллан, төлөвлөгөөнөөс 13,916.0 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ. Үндсэн үйл ажиллагаанаас 430,276.9 сая төгрөгийн борлуулалт хийж, 423,678.4 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргаж, 6,598.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

ЭХЗХ-ны 2023 оны 750 тоот тогтоолоор ДҮТ ХХК-д худалдах энергийн тарифыг 45.79 төг/кВт.ц-ийг 45.90 төг/кВт.ц, чадлын тарифыг 14,999,060.00 мянган төг/сар-г 12 дугаар сард 30,374,207.00 мянган төг/сар болгон өөрчилсөн нь ашигтай ажиллахад нөлөөлжээ.

ТӨБЗГ-т тайлант онд түрээсийн орлогын 40 хувь буюу 76.4 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн

компанийн үйл ажиллагааг сайжруулах үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, шилэн дансны мэдээлэл, худалдан авах ажиллагаа, дансны авлага, өглөгийн үлдэгдэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мишээл-Од Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Цогзолмаа, аудитор М.Цэнд-Аюуш, Х.Гэрэлбаяр, Э.Ундрах-Эрдэнэ, Т.Алтанчимэг, Э.Нямдулам нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Э.Энхцэцэг, захирал, тэргүүлэх аудитор Т.Одончимэг нар анхан шатны хяналтыг, Үндэсний аудитын газрын аудитор В.Эрдэнэцогт, аудитын менежер Ц.Хосжаргал, Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/165 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тогтоох эх сурвалжийг орлогын дэлгэрэнгүй тайлан, суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 331,435.7 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцон 3,314.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор компани 79.4 сая төгрөгийн дараах хэмнэлтүүдийг бий болгосон байна.Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 65.0 хувиар бууруулж төлөвлөсөн, ТЗБАХ-ийн ажил болох шинээр барилга барих, засварлах, тохижуулах зэрэг ажлуудад 1,000.0 сая гаруй төгрөг төлөвлөдөг байсныг тайлант онд төлөвлөгөөнд тусгаагүй;
- Зар сурталчилгааны зардлыг 30.0 хувиар бууруулж төлөвлөсөн;
- Судалгаа шинжилгээ, зураг төсвийн зардал төлөвлөгдөөгүй бөгөөд тус зардалд санхүүжилт олгоогүй, ажилчдын орон тоог 2 жилийн хугацаанд нэмэгдүүлээгүй;
- Томилолтын зардал 11.5 сая төгрөг, харилцаа холбооны зардал 4.6 сая төгрөг, хэвлэлийн зардал 0.2 сая төгрөг, гүйцэтгэх удирдлагын зардлыг 63.1 сая төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 846.5 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 778.2 сая төгрөгийн орлогын 9 гүйлгээ, 1 удаагийн 68.3 сая төгрөгийн зарлагын 1 гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна. Мөн 82,366.3 сая төгрөгийн орлогын 384 гүйлгээ, 74,236.4 сая төгрөгийн зарлагын 335 гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь иж бүрэн мэдээллийг мэдээлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Худалдан авах ажиллагааны тайланг аудитын байгууллагад дутуу, алдаатай бэлтгэж ирүүлсэн, тендерийн материалыг хуулийн шаардлагад нийцүүлэн тендерийн баримт бичигт заавал хавсаргах баримт бичгийг иж бүрнээр нь тендерийн баримтад хавсаргаагүй байна. Энэ нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална.”, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагч дараах үүрэгтэй: 16.1.1.төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны тайланг иж бүрэн, зөв бэлтгээгүй, тендерийн баримт бичгийн архивын нэгжийг үүсгэхдээ баримтыг дутуу бүрдүүлсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх;

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, горим, сорил хэрэгжүүлээ. Аудитаар 364,852.3 сая төгрөгийн 106 асуудал илрүүлж, аудитын явцад 275,187.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгасан ба бусад асуудлыг аудитын илрүүлэлт хэсэгт тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 5.8 сая төгрөгийн 1 акт, 81,254.8 сая төгрөгийн 5 албан шаардлага, 523.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна. Хэрэгжилтийг дахин хянахад 96.4 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	5,844.7	0	0.0	0.0
Албан шаардлага	5	81,254,794.1	5	78,332,457.0	96.4
Зөвлөмж	2	523,529.9	2	523,529.9	100.0
Нийт дүн	8	81,784,168.6	7	78,855,987.0	96.4

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн дараагийн аудитаар дараах анхаарах асуудлуудыг хамруулна. Үүнд:

- Эрчим хүчний сайдын 2023 оны А/291 дугаар тушаалаар Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түшингийн тодотгосон төлөвлөгөөгөөр их засварын төлөвлөгөөг 11,155.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан ба ажлын гүйцэтгэлийг хянах;
- Санхүүгийн программд зарцуулагдаж дуусан бараа материалыг хасах болон нэмэх үлдэгдэлтэйгээр тайлагнаж байгаа санхүүгийн программын алдааг засуулсан эсэх;
- Хойшлогдсон хөрөнгө, өр төлбөрийн тооцоололд үндсэн хөрөнгийн санхүүгийн болон татварын зорилгоор үлдэх өртгийн бүртгэсэн эсэх;
- Олон жилийн насжилттай барьцааны өглөг болон урьдчилж орсон орлогын үлдэгдлийн тооцооллыг авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 275.2 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 13 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа нь СТОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын Онолын үзэл баримтлал ЧШ-12-д “Үнэн зөв толилуулга - Санхүүгийн тайлан нь эдийн засгийн юмс үзэгдлийг үгээр болон тоогоор илэрхийлэн харуулдаг. Ач холбогдолтой байхын тулд санхүүгийн мэдээлэл нь холбогдох юмс үзэгдлийг зөвхөн илэрхийлэх төдийгүй өөрийн илэрхийлэн харуулахыг зорьж буй уг юмс үзэгдлийг үнэн зөв толилуулах ёстой” гэсэн заалт, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, батламж, мэдэгдлийг хангаагүйд дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Орлогын татварын зардлыг 2.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

- Өглөг авлагын тооцоо нийлэхдээ авлага, өглөгийн төрлөөр нь бус нийт дүнгээр тооцоо нийлснийг данс тус бүрийн үлдэгдлээр тооцоо нийлүүлсэн;
- Цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайланд 5.4 сая төгрөгийн цалин хөлсийг зөрүүтэй тайлагнасан;
- Харилцагч байгууллагуудын тооцоог авлага, өглөгийн журналд харилцагч үүсгэн бүртгэхдээ нэг харилцагчид олон код үүсгэн бүртгэснээс шалтгаалан харилцагчийн тооцоо хаагдаагүй, авлага өглөгийн товчоо тайланд хасах үлдэгдэлтэй өглөг, авлага тусгагдсан тооцоог нэгтгэн залруулан нийт 40,543.8 сая төгрөгийн авлага, 68,004.0 сая төгрөгийн өр төлбөрийн гүйлгээг залруулсан;
- Бэлтгэн нийлүүлэгчид төлөх өр төлбөрийг 0.3 сая төгрөг, бусад авлагын дүнг 0.5 сая төгрөгөөр тус тус илүү тайлагнасан;
- Бусад эргэлтийн бус хөрөнгийн үндсэн хөрөнгийн хувь тэнцүүлэн хасагдах НӨАТ-ын тооцоонд тайлагнах 26.3 сая төгрөгийг НӨАТ-ын авлагын дансанд тайлагнасан;
- Бусад эргэлтийн бус хөрөнгийн ангилалд тайлагнах үндсэн хөрөнгийн хувь тэнцүүлэн хасагдуулах 435.0 сая төгрөгийн НӨАТ-ын авлагыг эргэлтийн хөрөнгийн ангилалд тайлагнасан;
- ТБС арвижих ХХК-д төлсөн 9.8 сая төгрөгийн төлбөрийг урьдчилж төлсөн тооцоо данс руу залруулсан.
- Ерөнхий ба удирдлагын зардал болон үйл ажиллагааны бусад зардлын ангилалд тайлагнах 68.9 сая төгрөгийг борлуулсан бүтээгдэхүүний өртгийн ангилалд тайлагнасан;
- Гадаад валютаар илэрхийлэгдсэн дансны өглөгийн үлдэгдэлд ханшийн тэгшитгэл хийгээгүйгээс 73.1 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан;
- Урьдчилж орсон орлого, хойшлогдсон орлогын данстад бүртгэсэн 2.6 сая төгрөгийн тооцоог харилцагч хооронд залруулан бүртгэсэн;
- Аудитын залруулгуудтай холбоотойгоор ААНОАТ-ыг дахин тооцоолж 6.3 сая төгрөгийн татварын ногдлыг нэмэгдүүлсэн;
- Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийг 166,008.8 сая төгрөгөөр бууруулан урт хугацаат өр төлбөрийг нэмэгдүүлэн залруулсан.

Аудитаар нийт 13,895.7 сая төгрөгийн зөрчил², 34.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11,833.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,027.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 13,895.7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. ТУЗ-ийн даргын гадаад томилолтын зардал 15.4 сая төгрөгийг тус байгууллагаас зарцуулсан. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 10 гишүүнд 2022 оны ажлын үр дүнгийн шагналд 18.1 сая төгрөгийг олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: ... 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;..." "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ын 7.7-д "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ журамд заасан цалин хөлснөөс бусад баталгаа, хангамж эдлэхийг хориглоно.", 7.8-д "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөхөд нөхөн төлбөр, олговор зэрэг аливаа хэлбэрийн тэтгэмж олгохыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

3. Тайлант онд 2.0 сая төгрөгийг ТУЗ-ын хурлын зардалд зарцуулснаар тайлагнасан боловч түүнд 0.6 сая төгрөгийн анхан шатны баримтгүй зардлыг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1.энгийн хялбар, чанга хатуу байх; ... 4.1.6.сахилга баттай байх; ... 4.1.9.хариуцлагатай байх;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

1. Тайлан оны эцсийн байдлаар 9 харилцагчтай холбоотой 137.3 сая төгрөгийн өглөг, 31 харилцагчтай 281.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг давтан гаргасан, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өмнөх оны албан шаардлага хэрэгжүүлээгүй хуульд заасны дагуу хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

2. Тайлант оны жилийн эцсийн байдлаар 5 буюу түүнээс дээш жилийн хугацаанд ашиглагдаагүй 789 нэр төрлийн 3,171.8 сая төгрөгийн насжилт өндөртэй бараа материалын нөөц үүсгэсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: ... 15.1.6 нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх; ..." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хэрэгцээ шаардлагад үндэслэн бараа материалын нөөц үүсгээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх;

3. Худалдан авах ажлыг зохион байгуулж тендерт ялсан харилцагчтай гэрээг байгуулахдаа 6 төслийн 1,361.1 сая төгрөгийн гэрээний 40.8 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг гаргуулан аваагүй, 4 харилцагчтай байгуулсан 3,340.6 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээний хугацааг хэтрүүлэн нэмэлт гэрээ байгуулж, гэрээг сунгасан ч дахин гэрээний хугацаа хоцроосон байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн

биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана”, Ажил гүйцэтгэх гэрээний 5.1-д “Гэрээт ажлыг тендерийн баримт бичигт заагдсан ажлын эзлэхүүний дагуу нөхцөл шаардлагыг хангасан материалаар тендерт шалгарсан үнэд багтаан, батлагдсан графикт хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ”, 7.1-д “Гүйцэтгэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол гэрээнд урьдчилан заасан хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувийн алданги захиалагчид төлнө” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй, гэрээнд заасан хугацаанд ажлыг гүйцэтгээгүйд алданги тооцоогүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

4. Худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа “СММ ХХК”-д давуу эрх олгож 7 удаагийн 7,176.6 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан ба тендерт оролцогчийн ажиллах хүчин, хүний нөөцийн хүчин чадлын мэдээллүүд нь эдгээр ажлуудыг нэгэн зэрэг гүйцэтгэх нөөц боломжгүй, 5 ажлыг гүйцэтгэх хугацаа нь хоорондоо давхацсан байхад сонгон шалгаруулсан ба энэ нь 4,836.3 сая төгрөгийн 3 гэрээт ажлыг хугацаа хоцроож гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Мөн гэрээнд заасны дагуу хугацаа хоцроосон хоног тутамд 0.3 % алдангийг тооцоогүй, бэлэг дурсгалын зүйл, лого нийлүүлэх 157.6 сая төгрөгийн 1 ажил гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй байхад гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна. Энэ нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана”, Ажил гүйцэтгэх гэрээний 5.1-д “Гэрээт ажлыг тендерийн баримт бичигт заагдсан ажлын эзлэхүүний дагуу, нөхцөл шаардлагыг хангасан материалаар тендерт шалгарсан үнэд багтаан, батлагдсан графикт хугацаанд чанартай ийж гүйцэтгэнэ”, 7.1-д “Гүйцэтгэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол гэрээнд урьдчилан заасан хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувийн алданги захиалагчид төлнө” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийн сонгон шалгаруулалт хийхдээ гүйцэтгэгчийн хүчин чадлыг бодитой үнэлээгүй, гэрээт ажлын гүйцэтгэл, хугацаа хоцролтод алданги тооцоогүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх;

5. Ажлаас үндэслэлгүй чөлөөлсөн нь шүүхээр тогтоогдож ажилдаа эргүүлэн томилогдсон 1 ажилтанд ажилгүй байх хугацааны 16.9 сая төгрөгийн цалинг тус компаниас олгож байгууллагад хохирол учруулсан албан тушаалтнаас хохирлыг барагдуулаагүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлаас үндэслэлгүй чөлөөлсөн тушаал гаргасан буруутай албан тушаалтнаар хохирлыг барагдуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх;

6. Өмнөх оны аудитаар тавигдсан төлбөр барагдуулах тухай 4 ажилтантай холбоотой 11.2 сая төгрөгийн төлбөрийн акт болон албан шаардлагаас 8.6 сая төгрөгийг буруутай этгээдээс суутгаагүй, хохирлыг бүрэн барагдуулаагүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Х.Бекболат/-д даалгав.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант оны мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг түүвэрлэн авч цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 53 харилцагчтай холбоотой 591.2 сая төгрөгийн төлбөрийн цахим баримтыг харилцагчаар цахим системд дутуу шивүүлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Цахим төлбөрийн баримтыг гүйлгээ гарсан тухай бүрд нь цахим системд шивүүлж, хяналт хэрэгжүүлэх

Бараа материалтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Бараа материалын шаардах хуудсыг өөрийн байгууллагын онцлогт зориулан цахим хэлбэрт шилжүүлсэн ба анхан шатны баримт дээр үйлдвэрлэлийн эдийн засагч, нэгжийн дарга, төлөвлөлт эдийн засгийн хэлтэс, санхүү нягтлан, ерөнхий нягтлан бодогч зэрэг хүмүүсийн гарын үсгээр баталгаажуулахаар зохицуулсан боловч зөвшөөрсөн хүмүүсийн гарын үсгээр баталгаажуулаагүй зарлагын гүйлгээ хийсэн байна. Мөн бараа материалын журналд үлдэгдэл тоо ширхэггүй боловч хасах, нэмэх дүнгээр үлдэгдэлтэй тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: ... 5.1.4 үнэн зөв байх; ...”, 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг гарын үсгээр бүрэн баталгаажуулж, бараа материалын зарцуулалтад хяналт тавьж ажиллах;

3.1 Илрүүлэлт:

Тус компанийн 6 алба хэлтсийн шатахууны зарцуулалтад түүврээр анхан шатны баримттай тулган шалгахад 9,168.59 литр 21.9 сая төгрөгийн шатахууны жолоочийн тооцооны хуудас болон зарцуулалтыг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Жолоочийн тооцооны хуудаст бүртгэсэн явсан зам, шатахууны тооцоог бодож, зарцуулалтад хяналт хэрэгжүүлэх;

Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Тайлант онд телевизийн нэвтрүүлэг хийхэд 20.0 сая төгрөг, хурал зохион байгуулах зардалд 12.0 сая төгрөгийн худалдан авалтууд хийсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх," 15.2.3-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу телевизийн нэвтрүүлэг хийх зардлыг санхүүжүүлэхгүй байх, хурал зохион байгуулах зардлыг хэмнэж ажиллах;

Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 5446 нэр төрлийн 22,362.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үйл ажиллагаанд ашиглаж байгаа боловч үнийг шинэчлэн тогтоогоогүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

Цаашид ашиглах боломжтой элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн үнийг холбогдох журмын дагуу шинэчлэн тогтоож бүртгэлд тусгах;

6.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд 257,661.1 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл тусгагдсан байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд тусгагдаагүй буюу аль хөрөнгөд хамаарах нь тодорхойгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: ... 5.1.4 үнэн зөв байх;...", НББОУС 16 Үндсэн хөрөнгө стандартын 41-д "Үндсэн хөрөнгийн зүйлтэй холбоотойгоор өмчид тусгагдсан дахин үнэлгээний нэмэгдлийг тухайн хөрөнгийг үл зөвшөөрөх үед хуримтлагдсан ашиг дансанд шууд шилжүүлж болно. Энэ нь тухайн үндсэн хөрөнгийг актлах буюу данснаас хасах үед дахин үнэлгээний нэмэгдлийг бүхэлд нь шилжүүлэх ажиллагаа байж болно" заасны дагуу хасалт хийж, үлдэгдлийг үнэн зөв тайлагнаагүй байна.

6.2 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг нягтлан бодох бүртгэлийн журналд хөрөнгө тус бүрээр ангилж тусгах.

Татвартай холбоотой асуудал

7.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 6 нэр төрлийн үндсэн хөрөнгийн тоноглолын их засварт 12,866.6 сая төгрөгийн худалдан авалт хийж, өртгийг капиталжуулахдаа 1,286.6 сая төгрөгийн НӨАТ-ыг хувь тэнцүүлэн хасагдуулах НӨАТ-аар тооцоогүй, шууд хасалт хийсэн байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5-д "үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авах, импортлоход төлсөн албан татварыг дараах хугацаагаар хувь тэнцүүлэн хасагдуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

7.2 Өгсөн зөвлөмж:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу барилга, тоног төхөөрөмжийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг хувь тэнцүүлэн хасагдуулах;

Зардалтай холбоотой асуудал

8.1 Илрүүлэлт:

Хамтын гэрээний 9.1-д "ДЦС-4 ТӨХК-д тасралтгүй 20-с дээш жил ажиллаж байгаа ажилтанд 50, 60-н насны ойг тохиолдуулан тэдэнд эрхэлж байгаа албан тушаалын 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно" гэсэн заалтыг зөрчиж 4 ажилтанд 5.1 сая төгрөг, мөн дээрх болзлыг хангасан "өндөр настан, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон хүнд 50, 60, 70, 80, 90, 100-н насны ойгоор нь 60,000-110,000₮-н урамшуулал олгоно" гэсэн заалтыг зөрчиж 9 хүнд 0.7 сая төгрөгийг тус тус олгосон байна.

8.2 Өгсөн зөвлөмж:

Хамтын гэрээний дагуу олгож буй тэтгэмж, урамшууллын тооцооллыг хийхдээ анхан шатны баримтад үндэслэн зөрүүгүй тооцоолж олгох;

9.1 Илрүүлэлт:

Компанийн сургалтын зардлаас зориулалт бусаар /хувь хүн өөрөө хариуцах/ мэргэшсэн инженер, нягтлан бодогч, үнэлгээчин зэрэг мэргэжлийн эрх сунгахтай холбоотой төлбөрүүдэд 30.0 сая төгрөг төлсөн, шилэн кабелийн сургалт гэсэн гүйлгээний утгатай 48.9 сая төгрөгийг аяллын төлбөрт зарцуулсан байна. Мөн гишүүнчлэлийн хураамж, татварт 8 удаагийн гүйлгээгээр 11.4 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: ... 4.2.6.үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

9.2 Өгсөн зөвлөмж:

Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй зардалд компанийн хөрөнгийг зарцуулахгүй байх.

Дээрх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг Үндэсний аудитын газарт 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Орлогын татварын зардлыг 2.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан	1	2,200.0	1	2,200.0									
Өглөг авлагын тооцоо нийлэхдээ 2-оос дээш данстад үлдэгдэлтэй үед нийт дүнгээр тооцоо нийлдэг байсныг данс тус бүрийн үлдэгдлээр тооцоо нийлсэн аятад тусгасан	1		1										
Цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайланд 5.4 сая төгрөгийн цалин хөлсийг зөрүүтэй тайлагнасан	1	5,400.0			1	5,400.0							
ТӨБЭГ-т төвлөрүүлэх түрээсийн орлогыг 0.6 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн	1	648.0	1	648.0									
Харилцагч байгууллагуудын тооцоог авлага, өглөгийн журналд харилцагч үүсгэн бүртгэхдээ нэг харилцагчийг еер еер олон код үүсгэн бүртгэснээс шалтгаалан харилцагчийн тооцоо хаагдаагүй, авлага өглөгийн товчоо тайланд хасах үлдэгдэлтэй өглөг, авлага тусгагдсан. Аудитын зөвлөмжийн дагуу харилцагчийн тооцоог нэгтгэн залруулан нийт 40,543.8 сая төгрөгийн авлага, 68,004.0 мянган төгрөгийн ер төлбөрийн гүйлгээг залруулсан	1	108,547,778.4			1	108,547,778.4							
Бэлтгэн нийлүүлэгчид төлөх өр төлбөрийг 0.3 сая төгрөг, бусад авлагын дүнг 0.5 сая	1	802.0			1	802.0							

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зөрчлийн товч утга												
ТУЗ-ийн даргын гадаад томилолтын зардалд 15.4 сая төгрөгийг тус байгууллагаас зарцуулсан.	1	15.4	1	15.4								
Төлөөлөн удирдах зөвлөлийн 10 гишүүнд 2022 оны ажлын үр дүнгийн шагналд 18.1 сая төгрөгийг олгосон байна	1	18.1	1	18.1								
Тайлант онд 2.0 сая төгрөгийг ТУЗ-ын хурлын зардалд зарцуулснаар тайлагнасан боловч түүнд 637.6 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй зардлыг нягтлан бодох бүртгэлд тусгасан	1	0.6	1	0.6								
Тайлан оны эцсийн байдлаар 9 харилцагчтай холбоотой 137.3 сая төгрөгийн өлөг, 31 харилцагчтай холбоотой 281.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	418.7	1	418.7	1	418.7						
Тайлант оны жилийн эцсийн байдлаар 5 буюу түүнээс дээш жилийн хугацаанд ашиглагдаагүй 789 нэр төрлийн 3,171.8 сая төгрөгийн насжилт өндөртэй бараа материалын нөөц үүсгэсэн байна	1	3,171.8	1	3,171.8	1	3,171.8						

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<p>Гүйцэтгэлийн баталгаа гаргуулан авах 6 төсөл арга хэмжээний 1,361.1 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа 40.8 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг гаргуулан аваагүй, мөн гэрээний хугацаа хэтрүүлэн нэмэлт гэрээ байгуулсан ч дахин гэрээний хугацаа хоцроосон 4 харилцагчтай холбоотой 3,340.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн</p>	1	3,381.4	1	3,381.4	<p>"СММ ХХК" нь нийт 7 НТШ-д оролцож шалгарч 7,176.6 сая төгрөгийн ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Үүнд: Зуух №3 халах гадаргуун их засвар" 2,340.9 сая төгрөгийн ажлыг 2023.04.01-07.01- ны хооронд, Зуух №7 халах гадаргуун их засвар" 1,619.5 сая төгрөгийн ажлыг 2023.05.01-07.01- ны хооронд, Зуух №5 тоосон системийн их засвар" 724.9 сая төгрөгийн ажлыг 2023.07.01-09.01- ны хооронд, Зуух №1 тоосон системийн засвар" 826.1 сая төгрөгийн ажлыг 2023.05.01-07.01- ны хооронд, "Зуух, турбин цехүүдийн тоноглолуудын засварын үед гүйцэтгэх дулаалгын ажил" 1,227.1 сая төгрөгийн ажлыг 2023.05-2024-05 сарын хооронд хийж гүйцэтгэхээр тус тус гэрээ байгуулсан. "Зуух №7 халах гадаргуун их засварын ажлын тендерийн материалд хамааралгүй зүйлүүдийг хавсаргасан, тендэрт оролцогчийн ажиллах хүчин, ажиллагсдад олгодог цалингийн болон хүчин чадлын мэдээллүүд нь эдгээр том хэмжээний ажлуудыг нэгэн зэрэг гүйцэтгэх боломжгүй, ажил гүйцэтгэх хугацаа нь хоорондоо давхцсан байгаа нь 4,836.3 сая төгрөгийн 3 гэрээт ажлыг хугацаа хоцроож гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Мөн гэрээнд заасны дагуу хугацаа хоцроосон хоног тутамд 0.3 % алдангийг тооцоогүй, бэлэг дурсгалын зүйл, лого нийлүүлэх 157.6 сая төгрөгийн 1 ажил гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй байхад гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна.</p>	1	4,836.3	1	4,836.3	<p>Ажлаас үндэслэлгүй чөлөөлсөн нь шүүхээр тогтогдож ажилдаа эргүүлэн томилогдсон 1 ажилтанд ажилгүй байх хугацааны 16.9 сая төгрөгийн цалинг тус компаниас олгож хохирол учруулсан.</p>	1	16.9	1	16.9
---	---	---------	---	---------	--	---	---------	---	---------	--	---	------	---	------

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Өмнөх аудитаар өгөгдсөн "Тайлант онд 2 ажилтанд батлагдсан цалингаас 5.8 сая төгрөгийн цалин илүү олгосон", мөн "өмнөх оны аудитаар тогтоосон актаас 5.4 сая төгрөгийг дутуу суутгасан" гэсэн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй буюу байгууллагаас төлбөрийн актыг төлж, нийт 2.7 сая төгрөгийг ажилтнаас суутгаж, 8.7 сая төгрөгийг буруутай этгээдээс суутгаж хохирлыг бүрэн барагдуулаагүй байна.	1	8.6					1	8.6		
Тайлант оны мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг түүвэрлэн авч цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 53 харилцагчтай холбоотой 591.2 сая төгрөгийн төлбөрийн цахим баримтыг харилцагчаас дутуу гаргуулан авсан байна.	1	591.2		1	591.2					
Бараа материалын шаардах хуудсыг өөрийн байгууллагын онцлогт зориулан цахим хэлбэрт шилжүүлсэн ба анхан шатны баримт дээр үйлдвэрлэлийн эдийн засагч, нэгжийн дарга, төлөвлөлт эдийн засгийн хэлтэс, санхүү нягтлан, ерөнхий нягтлан бодогч зэрэг хүмүүсийн гарын үсгээр баталгаажуулахаар зохицуулсан боловч зөвшөөрсөн хүмүүсийн гарын үсгээр баталгаажуулаагүй зарлагын гүйлгээ хийсэн байна. Мөн бараа материалын журналд үлдэгдэл тоо ширхэггүй боловч хасах, нэмэх дүнгээр үлдэгдэлтэй тусгагдсан байна.	1			1						
Тайлант онд телевизийн нэвтрүүлэг хийхэд 20.0 сая төгрөг, хурал зохион байгуулах зардалд 12.0 сая төгрөгийн худалдан авалтууд хийсэн байна.	1	32.0		1	32.0					
Тус компанийн 6 алба хэлтсийн шатахууны зарцуулалтад түүврээр анхан шатны баримттай тулган шалгахад 9,168.59 литр 21.9 сая төгрөгийн шатахууны жолоочийн тооцооны хуудас болон зарцуулалтыг нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.	1	21.9		1	21.9					
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 5446 нэр төрлийн 22,362.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үйл	1			1						

СНАГ-2024/10/НА-СТА-ТӨА

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>						
Шилэн дансанд 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 9 удаагийн 778.2 сая төгрөгийн орлого, 1 удаагийн 68.3 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна. 384 удаагийн 82,366.3 сая төгрөгийн орлого, 335 удаагийн 74,236.4 сая төгрөгийн зарлагын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	846.5	1	846.5		
Дүн	1	846.5	1	846.5	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Худалдан авах ажиллагааны тайланг аудитын байгууллагад дуу, алдаатай бэлтгэж ирүүлсэн, тендерийн материалыг хуулийн шаардлагад нийцүүлэн тендерийн баримт бичигт заавал хавсаргах баримт бичгийг иж бүрнээр нь тендерийн баримтад хавсаргаагүй байна.	1	-	1	-		
Дүн	1	-	1	-		
Нийт дүн	2	846.5	2	846.5	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 дугаар сарын 25 № 143/0150055

Улаанбаатар хот

СНАГ - 2024/10/НА-СТА-ТӨА
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын гадаад томилолтын зардалд 15,371,547.20 /Арван таван сая гурван зуун далан нэгэн мянга таван зуун дөчин долоон төгрөг хорин мөнгө/ төгрөгийг тус байгууллагаас зарцуулсан.


Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын гадаад томилолтын зардалд зарцуулсан 15,371,547.20 төгрөгийг /Арван таван сая гурван зуун далан нэгэн мянга таван зуун дөчин долоон төгрөг хорин мөнгө/ Үндэсний аудитын газрын Төрийн сангийн Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулааны IV Цахилгаан Станц ТӨХК-ийн Гүйцэтгэх Захирал /У.Төмөрхуяг/, ерөнхий нягтлан бодогч /Д.Төмөртогтоо/ нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Акт\2024\0325\СНАГ-12.docx

0301090500



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 дугаар сарын 25 № 144/0150055

Улаанбаатар хот

СИАГ-2024/10/НА-СТА-ТӨА
Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 10 гишүүнд 2022 оны ажлын үр дүнгийн шагналд 18,100,000.00 /Арван найман сая нэг зуун мянга/ төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д "үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: ... 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;..." "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам"-ын 7.7-д "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ журамд заасан цалин хөлснөөс бусад баталгаа, хангамж эдлэхийг хориглоно.", 7.8-д "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөхөд нөхөн төлбөр, олговор зэрэг аливаа хэлбэрийн тэтгэмж олгохыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд олгосон шагналын 18,100,000.00 /Арван найман сая нэг зуун мянга/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулааны IV Цахилгаан Станц ТӨХК-ийн Гүйцэтгэх Захирал Ү.Төмөрхуяг/, ерөнхий нягтлан бодогч /Д.Төмөртогтоо/ нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26-230

Z_Aki 2024/0325 SIAG-12 Docx

0001090502



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 дугаар сарын 25 № 145/0150055

Улаанбаатар хот

СНАГ - 2024/10/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 2,000,000.00 /Хоёр сая/ төгрөгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын зардалд зарцуулснаар тайлагнасан боловч үүнээс 637,639.00 /Зургаан зуун гучин долоон мянга зургаан зуун гучин ес/ төгрөгийг анхан шатны баримтгүй зардлыг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1.энгийн хялбар, чанга хатуу байх; ... 4.1.6.сахилга баттай байх; ... 4.1.9.хариуцлагатай байх;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Анхан шатны баримтгүй зарцуулалтын 637,639.00 /Зургаан зуун гучин долоон мянган зургаан зуун гучин есөн / төгрөгийг Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /У.Төмөрхуяг/, ерөнхий нягтлан бодогч /Д.Төмөртогоо/ нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z_Akt-2024-0325_SNAG-12.Docx

0001090504



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25 № 716/0150055

Улаанбаатар хот

СНАГ - 2024/10/НА-СТА-ТӨА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлан оны эцсийн байдлаар 9 харилцагчтай холбоотой 137,347,942.00 /Нэг зуун гучин долоон сая гурван зуун дөчин долоон мянга есөн зуун дөчин хоёр/ төгрөгийн өглөг, 31 харилцагчтай 281,455,552.00 /Хоёр зуун наян нэгэн сая дөрвөн зуун тавин таван мянга таван зуун тавин хоёр/ төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг давтан гаргасан, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах.", 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж ажиллах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Ахлах нягтлан бодогч Д.Цэрэнхүүд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх Захирал /У.Төмөрхуяг/-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

0001080922



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25 № 717/0150055

Улаанбаатар хот

СНАГ-2024/10/НА-СТА-ТӨА
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны жилийн эцсийн байдлаар тав буюу түүнээс дээш жилийн хугацаанд ашиглагдаагүй 789 нэр төрлийн 3,171,788,018.00 /гурван тэрбум нэг зуун далан нэгэн сая долоон зуун наян найман мянга арван найман/ төгрөгийн насжилт өндөртэй бараа материалын нөөц үүсгэсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: ... 15.1.6 нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх; ..." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хэрэгцээ шаардлагад үндэслэн бараа материалын нөөц үүсгээгүй зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх Захирал /У.Төмөрхуяг/, ерөнхий няглан бодогч /Д.Төмөртоогоо/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ

0001000974



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25 № 918/0150055

Улаанбаатар хот

СНАГ-2024/10/ЧА-СТА-ТӨА
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажлыг зохион байгуулж тендерт ялсан харилцагчтай гэрээг байгуулахдаа 6 төслийн 1,361,107,538.00 /Нэг тэрбум гурван зуун жаран нэгэн сая нэг зуун долоон мянга таван зуун гучин найман/ төгрөгийн гэрээний гүйцэтгэлийн 40,833,000.00 /Дөчин сая найман зуун гучин гурван мянган/ төгрөгийн баталгааг гаргуулан аваагүй, 4 харилцагчтай байгуулсан 3,340,606,210.00 /Гурван тэрбум гурван зуун дөчин сая зургаан зуун зургаан мянга хоёр зуун арван/ төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээний хугацааг хэтрүүлэн нэмэлт гэрээ байгуулж, гэрээг сунгасан ч дахин гэрээний хугацааг хоцроосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Тендер шалгаруулалтын төсөөт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", Ажил гүйцэтгэх гэрээний 5.1-д "Гэрээт ажлыг тендерийн баримт бичигт заагдсан ажлын эзлэхүүний дагуу нөхцөл шаардлагыг хангасан материалаар тендерт шалгарсан үнэд багтаан, батлагдсан графикт хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ", 7.1-д "Гүйцэтгэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол гэрээнд урьдчилан заасан хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувийн алданги захиалагчид төлнө" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол;" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй, гэрээнд заасан хугацаанд ажлыг гүйцэтгээгүйд алданги тооцоогүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх Захирал /Ү.Төмөрхуяг/, ерөнхий нягтлан бодогч /Д.Төмөртоогоо/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 14 хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264330

Z: Alban Shoardlaga 2024 0325 SNAG-17.Docx

0001080926



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25 № 719/0150055
СНАГ-2024/10/НА-СТА-ТӨА
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа "СММ ХХК"-д давуу эрх олгож 7 удаагийн 7,176,595,335.00 /Долоон тэрбум нэг зуун далан зургаан сая таван зуун ерэн таван мянга гурван зуун гучин тав/ төгрөгийн ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан ба тендерт оролцогчийн ажиллах хүчин, хүний нөөцийн хүчин чадлын мэдээллүүд нь эдгээр ажлуудыг нэгэн зэрэг гүйцэтгэх нөөц боломжгүй, 5 ажлыг гүйцэтгэх хугацаа нь хоорондоо давхацсан байхад сонгон шалгаруулсан ба энэ нь 4,836,278,742.00 /Дөрвөн тэрбум найман зуун гучин зургаан сая хоёр зуун далан найман мянга долоон зуун дөчин хоёр/ төгрөгийн 3 гэрээт ажлыг хугацаа хоцроож гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Мөн гэрээнд заасны дагуу хугацаа хоцроосон хоног тутамд 0.3 % алдангийг тооцоогүй, бэлэг дурсгалын зүйл, лого нийлүүлэх 157,601,235.00 /Нэг зуун тавин долоон сая зургаан зуун нэг мянга хоёр зуун гучин тав/ төгрөгийн 1 ажлын гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй байхад гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", Ажил гүйцэтгэх гэрээний 5.1-д "Гэрээт ажлыг тендерийн баримт бичигт заагдсан ажлын эзлэхүүний дагуу, нөхцөл шаардлагыг хангасан материалаар тендерт шалгарсан үнэд багтаан, батлагдсан графикт хугацаанд чанартай ийж гүйцэтгэнэ", 7.1-д "Гүйцэтгэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол гэрээнд урьдчилан заасан хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувийн алданги захиалагчид төлнө" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол," гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр.
Утас 51-264230

Z Alban Shaardlaga 2024/0325 SNAG-17 Docx

0001080928

1. Тендерийн сонгон шалгаруулалт хийхдээ гүйцэтгэгчийн хүчин чадлыг бодитой үнэлээгүй, гэрээт ажлын гүйцэтгэл, хугацаа хоцролтод алданги тооцоогүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх Захирал Ү.Төмөрхуяг/, ерөнхий нягтлан бодогч /Д.Төмөртоогоо/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25

№ 720/0150055

Улаанбаатар хот

СНАГ-2024/10/НА-СТА-ТӨА
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны IV цахилгаан станц ТӨХК 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансанд 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 778,233,000.16 /долоон зуун далан найман сая хоёр зуун гучин гурван мянган төгрөг арван зургаан мөнгө/ төгрөгийн орлогын 9 гүйлгээ, 1 удаагийн 68.300,000.00 /жаран найман сая гурван зуун мянга/ төгрөгийн зарлагын 1 гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна. Мөн 82,366,318,505.73 /наян хоёр тэрбум гурван зуун жаран зургаан сая гурван зуун арван найман мянга таван зуун таван төгрөг далан гурван мөнгө/ төгрөгийн орлогын 384 гүйлгээ, 74,236,379,900.28 /далан дөрвөн тэрбум хоёр зуун гучин зургаан сая гурван зуун далан есөн мянга есөн зуун төгрөг хорин найман мөнгө/ төгрөгийн зарлагын 335 гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйлийн 6.4.4."таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн мэдээлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх Захирал /У.Төмөрхуяг/, ерөнхий нягтлан бодогч /Д.Төмөртогоо/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z: Alban Shaardlaga 2024 0325 SNAG-17 Docx

0001090930



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25 № 921/0150055

Улаанбаатар хот

СНАГ-2024/10/НА-СТА-Т0А

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны тайланг аудитын байгууллагад дутуу, алдаатай бэлтгэж ирүүлсэн, тендерийн материалыг хуулийн шаардлагад нийцүүлэн тендерийн баримт бичигт заавал хавсаргах баримт бичгийг иж бүрнээр нь тендерийн баримтад хавсаргаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д "Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална.", Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Шалгагдагч этгээд болон аудитад хамрагдагч дараах үүрэгтэй: 16.1.1.төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9.-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол," гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Худалдан авах ажиллагааны тайланг иж бүрэн, зөв бэлтгээгүй, тендерийн баримт бичгийн архивын нэгжийг үүсгэхдээ баримтыг дутуу бүрдүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх Захирал /У.Төмөрхуяг/, ерөнхий нягтлан бодогч /Д.Төмөртоогоо/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z. Alban Shaardlaga 2024/0325.SNAG-17.Docx

0001080932



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25 № 922/0150055

Улаанбаатар хот

СНАГ-2024/10/НА-СТА-ТӨА
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажлаас үндэслэлгүй чөлөөлсөн нь шүүхээр тогтоогдож ажилдаа эргүүлэн томилогдсон 1 ажилтанд ажилгүй байх хугацааны 16,908,755.20 /арван зургаан сая есөн зуун найман мянга долоон зуун тавин таван төгрөг хорин мөнгө/ төгрөгийн цалинг тус компаниас олгож байгууллагад хохирол учруулсан албан тушаалтнаас хохирлыг барагдуулаагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актД зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ажлаас үндэслэлгүй чөлөөлсөн тушаал гаргасан буруутай албан тушаалтнаар хохирлыг барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Хяналт-Шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Х.Бекболат/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264200

2. Албан Шаардлага 2024/0325 СНАГ-17 Док

0001780934



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 25 № 423/0150255

Улаанбаатар хот

СНАГ-2024/10/НА-СТА-ТӨА
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар тавигдсан төлбөр барагдуулах тухай 2023 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн №153/A0150116 дугаартай төлбөрийн акт болон 2023 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн №572/A0150116 дугаартай албан шаардлагаар тавигдсан төлбөрөөс төлөгдөөгүй 8,554,268.00 /Найман сая таван зуун тавин дөрвөн мянга хоёр зуун жаран найм/ төгрөгийг буруутай этгээдээс суутгаагүй, хохирлыг бүрэн барагдуулаагүй байна.


Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх аудитаар хохирлыг барагдуулахаар өгсөн акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Х.Бекболат/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z: Alban Shaardlaga 2024-0325 SNAAG-17 Docx

0001080936

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс